



НЭЭЛТТЭЙ СЭЛЭНГЭ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН УУЛЗАЛТ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

СУМ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГ:

Шаамар сум нь 1924 онд Орхон-Шаамар нэртэйгээр орхоны хөндий буюу халзангийн хаяа хэмээх газар анх байгуулагдсан. Сэлэнгэ аймгийн Бэлчирийн бүс хэсэгт оршиж, Улаанбаатар хотоос 330 км, аймгийн төвөөс 22 км зайд байрладаг. Ээж мод, Хайлаастын хурлын туурь зэрэг түүхэн газар, Партизан цэргийн болон төр нийгмийн нэрт зүтгэлтэн Г.Бумцэнд, Л.Цэнд, Ц.Сүрэн-Ухнаа нарын хөшөө, Шаамар-90 жил зөгийн үүр хөшөө, Орхон, Ерөө голын ай савууд, Дэлгэрхаан, Дулаанхаан, Бүүрэг толгой, Тужийн нарс зэрэг байгалийн үзэсгэлэнт газруудтай.



99107646



<http://shaamar.se.gov.mn>



Шаамар сум нь захиргааны нэгжийн хувьд Дэлгэрхаан, Охиндий, Дулаанхаан гэсэн 3 багийн нийт 1120 өрхөд 4052 хүн амьдардаг. 2022 оны жилийн эцсийн статистик тоон мэдээллээр: 0-18 насны хүүхэд 1436 буюу нийт хүн амын 35.3%, 15-34 насны залуучууд 1285 буюу нийт хүн амын 31.6% байна.



ТУС СУМЫН ХӨГЖИХ БОЛОМЖ:

2021-2024 онуудад “ӨРХИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖЬЕ” уриаг дэвшүүлж “Өрхийг дэмжих замаар ХАА-н гаралтай байгалийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, түүх дурсгалт газрыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлсэн өрх сум” болгох зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Зөгий аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, өрх бүрийг үйлдвэрлэгч болгох
- Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлж малчин өрхийг үйлдвэрлэгч болгох
- Хүлэмжийн аж ахуйг нэмэгдүүлж газар тариалан эрхлэгчдийг дэмжих
- Нутгийн байгалийн үзэсгэлэнт газруудыг түшиглэн Аялал жуулчлалыг хөгжүүлж өрхийн аж ахуйг хөгжүүлэх

Манай сумын 200 гаруй өрх зөгийн аж ахуй эрхэлдэг ба нийт 3880 бүлээс жилд 75007 л бал хураан авч эрүүл органик бүтээгдэхүүнээ зах зээлд нийлүүлж байна.

Шаамарын “Зөгийн бал” Сэлэнгэ аймгийн брэнд бүтээгдэхүүнээр шалгарч БАТЛАМЖЛАГДСАН.

Шаамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 31 дүгээр тоот тогтоолоор Сумын Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт хэрэгжих “Өрх бүрт хүлэмж” хөтөлбөрийг баталсан. Хөтөлбөрийн хүрээнд 2022, 2023 онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр 6*20 м хэмжээтэй 80 ш хүлэмж, Хөдөөгийн хөгжлийг дэмжих төслөөс 8 ш хүлэмж, ДЗОУБ-ын ОНХХ-өөс 14ш хүлэмж, ХХААЯ-ны захиалгаар 30 ш хүлэмжний “АГРО ПАРК” -ийг тус тус байгуулсан.



ЗДТГ дээрх хүлэмжнүүдээ иргэддээ түрээслүүлснээр өрхүүд дунджаар 4,000,000 - 8,000,000 төгрөгийн орлого олж өрхийн амьжиргаагаа дээшлүүлэн ажиллаж байна.

Шаамар суманд төмсхүнснийногоо тариалах, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой. Зах зээлд ойр, зам харилцаа хөгжсөн.

